



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/08/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Vujinkhandj@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас:99282488 Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25

№

99

танай

-ны №

-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тээвэр шатахууны зардлаас анхан шатны баримтгүй зарцуулсан, санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт илүү, дутуу зөрүүтэй тайлагнасан зэрэг нийт 23.2 сая төгрөгийн зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	147,307,238.00	175,160,618.00
33	АВЛАГА	24,512,200.00	20,511,080.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	24,512,200.00	20,511,080.00
35	БАРАА МАТЕРИАЛ	122,795,038.00	154,649,538.00
35400	Хангамжийн материал	5,526,288.00	16,179,788.00
35410	Бичиг хэргийн материал	545,500.00	411,000.00
35420	Аж ахуйн материал	4,680,788.00	15,468,788.00
35450	Барилгын засварын материал	300,000.00	300,000.00
35500	Биологийн хөрөнгө	0.00	21,201,000.00
35600	Мал амьтад	117,268,750.00	117,268,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	734,145,587.84	822,138,226.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	734,145,587.84	822,138,226.24
39200	Биет хөрөнгө	531,546,387.84	619,539,026.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	624,193,831.96	389,663,159.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	-411,325,228.24	-167,440,690.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	209,078,119.00	190,771,360.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-105,242,634.51	-109,561,315.03
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	57,288,740.00	71,429,542.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,435,297.88	-32,971,539.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,983,486.00	9,197,950.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,196,806.17	-5,501,398.45
39209	Зам, гүүрийн байгууламж	385,864,528.00	498,595,228.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-200,136,495.32	-225,117,414.80
39217	Ном	474,145.00	474,145.00
39300	Биет бус хөрөнгө	202,599,200.00	202,599,200.00
39301	Программ хангамж	1,710,000.00	1,710,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,710,000.00	-1,710,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	203,349,200.00	203,349,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-750,000.00	-750,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	881,452,825.84	997,298,844.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	788,000.00	132,300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	788,000.00	132,300.00
41300	Өглөг	788,000.00	132,300.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	132,300.00
41360	Бусад өглөг	788,000.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	788,000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	880,664,825.84	997,166,544.24
51	Засгийн газрын хувь оролцоо	880,664,825.84	997,166,544.24
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	437,621,320.45	437,621,320.45
51200	Хуримтлагдсан үр дүн	243,910,288.53	360,412,006.93
51210	Өмнөх үеийн үр дүн	187,634,266.55	243,910,288.53
51220	Тайлант үеийн үр дүн	56,276,021.98	116,501,718.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	199,133,216.86	199,133,216.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	881,452,825.84	997,298,844.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	428,199,724.00	515,197,305.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,117,203.00	209,240,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	140,117,203.00	209,240,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,117,203.00	209,240,700.00

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	140,117,203.00	209,240,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	288,082,521.00	305,956,605.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,640,221.00	3,988,605.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	1,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,042,221.00	2,151,445.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	598,000.00	337,160.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	269,442,300.00	301,968,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	269,442,300.00	301,968,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	371,923,702.02	398,695,586.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	371,923,702.02	398,695,586.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,990,482.87	387,390,596.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,258,682.57	197,226,163.45
210101	Үндсэн цалин	161,992,167.29	166,199,963.45
210102	Нэмэгдэл	8,551,960.55	0.00
210104	Урамшуулал	21,917,269.46	21,714,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,797,285.27	9,312,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,994,248.28	24,769,661.31
210201	Тэтгэврийн даатгал	16,049,249.39	16,853,661.31
210202	Тэтгэмжийн даатгал	1,986,199.67	2,023,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	397,300.00	1,571,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,588,999.50	392,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,972,499.72	3,928,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,264,912.00	21,696,336.76
210301	Гэрэл, цахилгаан	1,170,312.00	1,268,336.76
210302	Түлш, халаалт	20,894,600.00	20,328,000.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,544,780.00	20,689,120.00
210401	Бичиг хэрэг	2,226,750.00	2,911,650.00
210402	Тээвэр, шатахуун	13,472,800.00	16,189,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,847,280.00	926,970.00
210404	Ном, хэвлэл	0.00	47,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	428,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	569,950.00	613,800.00
2105	Нормативт зардал	1,323,075.00	881,080.00
210502	Хоол, хүнс	0.00	250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,323,075.00	631,080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	3,062,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	67,000.00
210604	Урсгал засвар	0.00	2,995,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,660,000.00	1,734,000.00
210702	Дотоод албан томилолт	1,660,000.00	1,734,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,835,190.00	1,446,583.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,114,921.00	551,445.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,140.00	294,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,504.00	131,688.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	39,125.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	410,500.00	0.00
210807	Газрын төлбөр	110,000.00	381,000.00

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,109,595.02	115,885,651.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,496,325.00	17,060,590.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,048,289.00	460,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,564,981.02	98,365,061.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,933,219.15	11,304,990.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	981,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	981,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,952,219.15	9,804,990.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,952,219.15	9,793,910.48
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	11,080.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	56,276,021.98	116,501,718.40
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	56,276,021.98	116,501,718.40

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	437,621,320.45	199,133,216.86	187,634,266.55	824,388,803.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	437,621,320.45	199,133,216.86	187,634,266.55	824,388,803.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	56,276,021.98	56,276,021.98
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	437,621,320.45	199,133,216.86	243,910,288.53	880,664,825.84
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	437,621,320.45	199,133,216.86	243,910,288.53	880,664,825.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	437,621,320.45	199,133,216.86	243,910,288.53	880,664,825.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	116,501,718.40	116,501,718.40
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	437,621,320.45	199,133,216.86	360,412,006.93	997,166,544.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	316,082,521.00	309,968,805.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	316,082,521.00	309,968,805.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,640,221.00	8,000,805.00

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	1,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,042,221.00	6,154,645.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	598,000.00	346,160.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	269,442,300.00	301,968,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	269,442,300.00	301,968,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	314,182,521.00	301,420,805.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,182,521.00	301,420,805.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	286,737,101.85	290,104,734.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,258,682.57	197,226,163.45
210101	Үндсэн цалин	161,992,167.29	166,199,963.45
210102	Нэмэгдэл	8,551,960.55	0.00
210104	Урамшуулал	21,917,269.46	21,714,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,797,285.27	9,312,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,994,248.28	24,637,361.31
210201	Тэтгэврийн даатгал	16,049,249.39	16,721,361.31
210202	Тэтгэмжийн даатгал	1,986,199.67	2,023,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	397,300.00	1,571,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,588,999.50	392,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,972,499.72	3,928,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,264,912.00	21,696,336.76
210301	Гэрэл, цахилгаан	1,170,312.00	1,268,336.76
210302	Түлш, халаалт	20,894,600.00	20,328,000.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,644,380.00	20,509,620.00
210401	Бичиг хэрэг	2,496,350.00	2,945,950.00
210402	Тээвэр, шатахуун	13,472,800.00	16,189,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,847,280.00	926,970.00
210404	Ном, хэвлэл	0.00	47,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	428,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	399,950.00	400,000.00
2105	Нормативт зардал	1,323,075.00	881,080.00
210502	Хоол, хүнс	0.00	250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,323,075.00	631,080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	3,665,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	782,000.00
210604	Урсгал засвар	0.00	2,883,000.00
2107	Томилолт, зочны зардал	872,000.00	2,522,000.00
210702	Дотоод албан томилолт	872,000.00	2,522,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,835,190.00	1,446,583.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,114,921.00	551,445.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,140.00	294,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,504.00	131,688.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	39,125.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	410,500.00	0.00
210807	Газрын төлбөр	110,000.00	381,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,544,614.00	17,520,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,682,025.00	17,060,590.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	862,589.00	460,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,445,419.15	11,316,070.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	981,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	981,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,464,419.15	9,816,070.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,952,219.15	9,804,990.48

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	24,512,200.00	11,080.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,900,000.00	8,548,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,900,000.00	8,548,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,900,000.00	8,548,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,900,000.00	8,548,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,900,000.00	8,548,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,900,000.00	-8,548,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	301,968,000.00	292,163,009.52	9,804,990.48	97%
УРСГАЛ ЗАРДАЛ	301,968,000.00	292,163,009.52	9,804,990.48	97%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	300,468,000.00	290,663,009.52	9,804,990.48	97%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	196,415,600.00	195,953,963.45	461,636.55	100%
Үндсэн цалин	166,661,600.00	166,199,963.45	461,636.55	100%
Урамшуулал	21,714,000.00	21,714,000.00	0.00	100%
Гэрээт ажлын хөлс	8,040,000.00	8,040,000.00	0.00	100%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,611,300.00	24,532,361.31	78,938.69	100%
Тэтгэврийн даатгал	16,695,300.00	16,616,361.31	78,938.69	100%
Тэтгэмжийн даатгал	2,023,600.00	2,023,600.00	0.00	100%
ҮОМШӨ-ний даатгал	1,571,300.00	1,571,300.00	0.00	100%
Ажилгүйдлийн даатгал	392,800.00	392,800.00	0.00	100%
Эрүүл мэндийн даатгал	3,928,300.00	3,928,300.00	0.00	100%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,928,000.00	21,696,336.76	231,663.24	99%
Гэрэл, цахилгаан	1,500,000.00	1,268,336.76	231,663.24	85%
Түлш, халаалт	20,328,000.00	20,328,000.00	0.00	100%
Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	0.00	100%
Хангамж, бараа материалын зардал	19,492,800.00	18,909,620.00	583,180.00	97%
Бичиг хэрэг	2,800,000.00	2,795,950.00	4,050.00	100%
Тээвэр, шатахуун	14,750,000.00	14,750,000.00	0.00	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,492,800.00	916,170.00	576,630.00	61%
Ном, хэвлэл	50,000.00	47,500.00	2,500.00	95%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	400,000.00	0.00	100%
Эд хогшил, урсгал засварын зардал	12,414,100.00	12,213,000.00	201,100.00	98%
Багаж, техник, хэрэгсэл	9,530,000.00	9,330,000.00	200,000.00	98%
Урсгал засвар	2,884,100.00	2,883,000.00	1,100.00	100%
Томилот, зочны зардал	6,500,000.00	2,522,000.00	3,978,000.00	39%
Дотоод албан томилот	6,500,000.00	2,522,000.00	3,978,000.00	39%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,851,000.00	895,138.00	955,862.00	48%
Даатгалын үйлчилгээ	360,000.00	294,450.00	65,550.00	82%
Тээврийн хэрэгслийн татвар	432,000.00	131,688.00	300,312.00	30%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	88,000.00	62,000.00	59%
Газрын төлбөр	381,000.00	381,000.00	0.00	100%

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	17,255,200.00	13,940,590.00	3,314,610.00	81%
Бараа үйлчилгээний бусад зардал	15,755,200.00	13,480,590.00	2,274,610.00	86%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	460,000.00	1,040,000.00	31%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,500,000.00	0.00	100%
Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	301,968,000.00	301,968,000.00	0.00	100%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	301,968,000.00	301,968,000.00	0.00	100%
Орон нутгийн төсвөөс	301,968,000.00	301,968,000.00	0.00	100%
"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	0.00
"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	8,832,645.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	8,832,645.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,989,725.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,272,200.00
Гэрээт ажлын хөлс		1,272,200.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	105,000.00
Тэтгэврийн даатгал		105,000.00
Хангамж, бараа материалын зардал	-	1,600,000.00
Бичиг хэрэг		150,000.00
Тээвэр, шатахуун		1,439,200.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		10,800.00
Нормативт зардал	-	881,080.00
Хоол, хүнс		250,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		631,080.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	551,445.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		551,445.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,580,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		3,580,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	842,920.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	842,920.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		842,920.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	8,832,645.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,832,645.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,500,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,986,485.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		346,160.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 3/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дарив сумын Засаг даргын тамгын газар нь “Сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 371.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 997.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 19.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15.9 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дарив сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13 хувиар буюу 115.8 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамжийн материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 20.5 сая төгрөг болж өссөн нь гүйцэтгэлээр санхүүжиж байгууллагаас авах авлагатай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 154.6 сая төгрөг болж 31.8 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 19.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 31.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авч үйл ажиллагаандаа 18.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 822.1 сая төгрөг болж 88.0 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 177.8 сая төгрөгийн барилга байгууламж, зам гүүрний барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой.

Өглөг дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг болж буурсан нь хувь хүмүүстэй холбоотой авлага барагдан, нийгмийн даатгалд өгөх өглөгтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 997.2 сая төгрөг болж 116.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 20 хувиар буюу 87.0 сая төгрөгөөр өссөн нь санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 360.4 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 354.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 52.5 сая төгрөгөөр бууруулж, 302.0 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь цалингийн зардал буурсантай холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 302.0 сая төгрөгийн төсөв баталсан.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 302.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 292.2 сая төгрөгийг зарцуулж, 9.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 292.2 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь ажил олгогчоос цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 0.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.5 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 0.2 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 4.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 6.1 сая төгрөгийг, төсөв байгууллагын өөрийн орлого 0.3 сая төгрөгийг, хандиваар 1.5 сая төгрөгийн орлого хүлээн авч оны эцэст 0.01 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн. Нэмэлт санхүүжилтийн орлогыг цалин хөлс, хангамж, бараа материал, нормативд зардал, бусдаар гүйцэтгүүлэх, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 447.7 сая төгрөгийн 37 мэдээллийг ил тод байршуулахаас 24.4 сая төгрөгийн 10 мэдээллийг ил тод байршуулж, 423.3 сая төгрөгийн 27 мэдээллийг мэдээлээгүй байсныг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 162.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 заалт бүхий албан шаардлага, 3.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 1 заалт зөвлөмжийг хүргүүлж бүрэн хэрэгжсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар бараа материалын дансны үлдэгдэл, тээвэр шатахууны зарцуулалтыг тулган баталгаажуулах, авлага, өглөгийн барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 204.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 179.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 24.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Нэр бүхий 1 компаниас 1.9 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн. Мөн санхүүгийн тайланд 2.0 сая төгрөгийг, үр дүнгийн тайланд 175.5 сая төгрөгийн залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Тээвэр шатахууны зардлаас 0.3 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 20.9 сая төгрөгөөр илүү, 2.0 сая төгрөгөөр дутуу зөрүү гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

И-баримтгүй 1.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын

гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт " Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 37 мэдээлэл мэдээлэхээс 27 мэдээлэл хоцроож мэдээлсэн.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг мөрдөн мэдээллээ бүрэн оруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дарив сумын Засаг даргын тамгын газрын	4	204.0	2	179.4	1	0.3	3	24.3	1	0